

- Хөрсний ялзмаг

Ялзмаг нь хөрсний үржил шимийг тодорхойлох үндсэн үзүүлэлт болдог. Хөрсөнд хэдий чинээ их ялзмагтай байна, төдий чинээ ус, агаар, дулаан, физик-химийн шинж чанар нь сайн байна.

Шинжилгээнд хамрагдсан сорьцнуудын хувьд ялзмагийн агууламжийн хувь нь 1.421-2.373 хооронд байна. Мөн чийгийн агууламж 16.61-33.74%, сульфатын агууламж 3443.35-4160.84 мг/кг, хөдөлгөөнт фосфорын агууламж 108.11-153.76 мг/кг, нитратын агууламж 33.16-171.41 мг/кг, аммоны агууламж 28.82-75.71 мг/кг байна.

2. Хүнд металлын хяналт-шинжилгээ

Хөрсний чанарын хүнд металлын үзүүлэлтийг доорхи график3.4.5-д тус тус харуулав.




График3. Цэвэрлэх байгууламж орчмын хөрсөнд агуулагдах хүнд металлуудын агууламж




График4. Богдын голын гэр хороололын хөрсөнд агуулагдах хүнд металлуудын агууламж




График5. Уурын зуух орчмын хөрсөнд агуулагдах хүнд металлуудын агууламж

Сүүлийн 3 жилийн хугацаан дах хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламжийг харьцуулан авч үзэхэд Цэвэрлэх байгууламж орчмын хөрсөнд 2021 онд стронцийн агууламж бусад онтой харьцуулахад өндөр байсан бол кадмийн агууламж 2023 онд бага хэмжээтэй; Богдын голын гэр хороололын хөрсөнд 2021 онд Цезийн агууламж бага зэргийн өсөлттэй хэдий ч 2022 онд стронцийн агууламж бусад онтой харьцуулахад өндөр байсан бол 2021 онд мөнгөн усны агууламж бага хэмжээтэй; Уурын зуух орчмын хөрсөнд 2021 онд цезийн агууламж болон стронцийн агууламж өсөлттэй хэдий ч 2023 онд цайрын агууламж өндөр байсан бол 2021 онд мөнгөн усны агууламж бага хэмжээтэй харагдаж байна.

MNS 5850:2019 стандарттй харьцуулахад 2023 онд Уурын зуух орчмын хөрсөнд агуулагдах кадмийн агууламж 1 дахин, хар тугалганы агууламж 1.1 дахин, цайрын агууламж 1.9 дахин тус тус зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан байна. Мөн Богдын голын гэр хороололын хөрсөнд агуулагдах цайрын агууламж 1.3 дахин зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан тохиолдлууд ажиглагдаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН: БОШЛ-ИЙН ИНЖЕНЕР
ХЯНАСАН: БОШЛ-ИЙН ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ
ИНЖЕНЕР, ЧАНАРЫН МЕНЕЖЕР

Б.МЯГМАР
З.БАЛЖИННЯМ